



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Говь Гурван сайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/151/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Даланзадгад хот
2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс аудит” ХХК

Захирал: Ш.Ичинхорлоо
Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	221.3	221.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	272.0	282.4
	Нийт хөрөнгийн дүн	493.3	504.3
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	493.3	504.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	493.3	504.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	637.5	584.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	567.9	573.4
	Үйл ажиллагааны үр дүн	69.6	11.1
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	69.6	11.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	154.8	154.8
	Тайлант оны үр дүн	338.4	349.4
	Эцсийн үлдэгдэл	493.2	504.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	539.9	528.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	539.9	528.9
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	528.6	518.5
	Урсгал зардал	528.6	518.5
	Хөрөнгийн зардал	-	0



	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	528.6	518.5
	Улсын төсвөөс санхүүжих	512.6	512.6
	Орон нутгийн төсвөөс		
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	16.0	5.9

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Говь Гурван сайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа эрхэм зорилгоо “Говь гурван сайхан уулсын биологийн төрөл зүйл, экологийн тэнцвэрт байдал, тэдгээрийн унаган төрхийг хадгалан хамгаалах, хойч үеийхэндээ өвлүүлэн үлдээхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах үйл ажиллагааны чиглэлтэй байна. Үүнд:

- Судалгаа шинжилгээ
- Хяналт шалгалт
- Байгалийн нөөцийн хамгаалал
- Аялал жуулчлал
- Сургалт сурталчилгаа

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчаас үнэ төлбөргүй балансаас балансад 38,826.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлсэн ба орон нутгийн төсвөөс олгосон 30,000.0 мянган төгрөгөөр тавилга тоног төхөөрөмжийг худалдан авч бэлтгэсэн байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Өмнөговь аймгийн Говь Гурван сайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 25 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 70.0 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт илэрсэн 14,304.9 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, 3 зөвлөмж өгсөн.



7.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

д/д	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бараа материалын үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс өссөн үзүүлэлтэй байна.	1	588.0							1	588.0
2	Тайлант онд цахим төлбөрийн системд нийт 13,716.9 мянган төгрөгийн баримт шивэгдээгүй байгааг хянаж, залруулаагүй байна.	1	13,716.9							1	13,716.9
3	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна	1	-							1	-
	Нийт дүн	3	14,304.9							3	14,304.9